

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“21.1.Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогод доор дурдсан хувиар тооцож, албан татвар ногдуулна:

21.1.1.нийслэл Улаанбаатар хотод оршин суудаг, тус хотод бүртгэлтэй албан татвар төлөгчийн орлогод 5 хувиар;

21.1.2.аймаг, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 1000 хүртэл км хол алслагдсан аймаг, суманд оршин суудаг, тухайн орон нутагт бүртгэлтэй албан татвар төлөгчийн орлогод 3 хувиар;

21.1.3.аймаг, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд оршин суудаг, тухайн орон нутагт бүртгэлтэй албан татвар төлөгчийн орлогод 1 хувиар.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг